



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/133

Улаанбаатар хот

Чанарын удирдлагын баг томилж
ажиллуулах тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8-д заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагаанд “Чанарын менежментийн тогтолцооны стандарт MNS ISO 9001:2016”-ыг нэвтрүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллах үүрэг бүхий Чанарын удирдлагын багийг хавсралтад заасан бүрэлдэхүүнтэйгээр томилон ажиллуулсугай.

2. Энэ тушаалын 1 дэх заалтад заасан Чанарын удирдлагын багийн ажлыг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажлын явц, үр дүнг яамны удирдлагын шуурхай зөвлөгөөнд тухай бүр танилцуулж ажиллахыг Чанарын удирдлагын баг /Б.Гүнболд/, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /О.Лхагвацэдэн/-т тус тус даалгасугай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

С.МАГНАЙСҮРЭН



151080442

Барилга, хот байгуулалтын яамны
Төрийн нарийн бичгийн даргын
2021 оны...11... дугаар сарын
...01... ны өдрийн...11133... дугаар
тушаалын хавсралт

“Чанарын менежментийн тогтолцооны стандарт MNS ISO 9001:2016”-ыг
нэвтрүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллах үүрэг бүхий
Чанарын удирдлагын багийн бүрэлдэхүүн

Ахлагч:

- Бодлого, төлөвлөлтийн газрын дарга;

Дэд дарга:

- Төрийн захиргааны удирдлагын газрын дарга;

Гишүүд:

- Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
- Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
- Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
- Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий санхүүч;
- Төрийн захиргааны удирдлагын газрын Статистик, мэдээллийн технологийн хэлтсийн дарга;
- Төрийн захиргааны удирдлагын газрын Хүний нөөцийн бодлого, зохицуулалт хариуцсан ахлах шинжээч;
- Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хот байгуулалтын нэгдсэн бодлого, зохицуулалт хариуцсан ахлах шинжээч;
- Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Барилга байгууламжийн үйлдвэрлэлийн бодлого, зохицуулалт хариуцсан ахлах шинжээч;
- Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлого, зохицуулалт хариуцсан ахлах шинжээч;

- Бодлого, төлөвлөлтийн газрын Салбарын норм, норматив, техникийн бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээч;
- Хуулийн хэлтсийн Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн салбарын эрх зүйн зохицуулалт хариуцсан шинжээч;
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан шинжээч.

Нарийн бичгийн дарга:

- Төрийн захиргааны удирдлагын газрын Салбарын сургалт, ажиллах хүчний бодлого, зохицуулалт хариуцсан ахлах шинжээч.

-----***-----